



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/33/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас: 261885 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Стандарт дүгнэлт аудит
ХХК: Захирал: В.Даваасүрэн
Утас: 70111721 Цахим хаяг: info@sda-audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9-10
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
4.1 Байгууллагын үйл ажилагаа.....	13
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	14-15
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	15-16
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	16-15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Залруулсан алдаа	18-19
8.2 Албан шаардлага	18
8.3 Зөвлөмж.....	19
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20-21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/534
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тус байгууллага нь өөрийн эзэмшиж байгаа байрыг 49 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд гэрээгээр түрээслүүлэн тайлант онд 634.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан бөгөөд ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад асуудал

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь тайлант онд Хятад улсын Хуавай ХК-тай хамтран ажиллах төсөл хэрэгжүүлж, нийт 506.3 сая төгрөгийн видео хурлын тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 87 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулалт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21,698,550.84	1,606,875.52
1.1.2	Дансны авлага	228,882,367.91	281,897,254.51
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	80,168,470.82	88,382,275.71
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,052,080.00	2,092,036.61
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	331,801,469.57	373,978,442.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,836,213,516.77	3,205,844,876.24
1.2.2	Биет бус хөрөнгө	673,280,000.00	673,280,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,509,493,516.77	3,879,124,876.24
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,841,294,986.34	4,253,103,318.59
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	100,278,326.58	101,030,139.08
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	143,489,822.47	121,194,215.67
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	37,041,000.00	468,847,069.30
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	280,809,149.05	691,071,424.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	4,370,825.15	3,848,610.15
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,370,825.15	3,848,610.15
2.2	Өр төлбөрийн нийт дүн	285,179,974.20	694,920,034.20
2.3	Эздийн өмч		

2.3.1	Өмч:-төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.2	хувийн	0.00	0.00
2.3.3	хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,213,222,704.68	3,207,725,219.64
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	789,494,381.42	789,494,381.42
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,468,232,273.96)	(1,460,666,516.67)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,556,115,012.14	3,558,183,284.39
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,841,294,986.34	4,253,103,318.59

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	909,568,979.12	1,196,705,604.92
2	Борлуулалтын өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг(алдагдал)	909,568,979.12	1,196,705,979.12
4	Түрээсийн орлого	603,762,885.15	620,417,440.51
5	Хүүний орлого	151,937.79	0.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/	0.00	68,964,933.74
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	305,654,156.18	507,323,230.67
9	Борлуулалт, маркетингийн зардал	42,937,977.37	118,185,414.04
10	Ерөнхий ба удирдлагын зардал	802,225,693.80	860,079,782.22
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Элэгдлийн зардал	182,912,103.36	208,272,647.80
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	0.00
17	Бусад зардал	0.00	7,670,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(118,506,795.41)	2,497,760.86
19	Орлогын татварын зардал	15,193.79	229,808.03
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(118,521,989.20)	2,267,952.83
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(118,090,527.36)	2,068,272.25
23	Бусад дэлгэрэнгүй орлого	431,461.84	(199,680.58)
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	431,461.84	0.00
	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	(199,680.58)
24	Орлогын нийт дүн	(118,090,527.72)	2,068,272.25

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42	0.00	3,213,222,704.68	0.00	(1,350,141,746.60)	3,674,205,539.50
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	(118,090,527.36)	(118,090,527.36)
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42	0.00	3,213,222,704.68	0.00	(1,468,232,273.96)	3,556,115,012.14
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	2,068,272.25	2,068,272.25
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			(5,497,485.04)		5,497,485.04	0.00
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42		3,207,725,219.64	0.00	(1,460,666,516.67)	3,558,183,284.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	939,352,494.17	1,181,476,785.97
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	569,432,703.50	800,741,992.28
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,120,426.00	6,333,538.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	363,799,364.67	374,401,255.69
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	946,778,109.95	1,127,705,710.83
	Ажиллагчдад төлсөн	323,836,276.00	362,793,598.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	104,129,950.26	120,547,957.40
	Бараа материал худалдан авахад төлсөн	45,213,890.81	33,007,626.49
	Ашиглалтын зардалд төлсөн	129,664,822.59	119,344,811.92
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,496,400.00	6,148,250.00
	Газрын төлбөр	6,727,680.00	6,727,680.00
	Татварын байгууллагад төлсөн	166,564,756.33	195,752,570.42
	Даатгалын төлбөрт төлсөн	5,970,426.00	6,333,538.00
	Бусад мөнгөн зарлага	160,173,907.96	277,049,678.60
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,425,615.78)	53,771,075.14
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,442,413.47	4,933,298.77
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	8,290,475.68	4,933,298.77
	Хүлээн авсан хүүний орлого	151,937.79	0.00
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
		0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	55,997,705.00	81,161,049.23
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	45,283,665.00	71,585,049.23
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00

	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	10,714,040.00	9,576,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(47,555,291.53)	(76,227,750.46)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,981,174.37	7,460,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	11,600,000.00	7,460,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	381,174.37	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,772,621.22	5,095,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,733,820.00	5,095,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	38,801.22	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,208,553.15	2,365,000.00
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(44,772,354.69)	(20,091,675.32)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,470,905.00	21,698,550.84
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,698,550.84	1,606,875.52

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7	8
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	Мэдээлэл технологийн сургалт	биет	56.3	456.3	242.6	(213.7)	53.2
	Инкубаторын үйл ажиллагаа	биет	170.5	215.6	202.9	(12.7)	94.1
	Төсөл хөтөлбөр	биет	240.9	263.7	261.3	(2.4)	99.1
	Түрээсийн үйлчилгээ	биет	583.7	634.8	645.8	11.0	101.7
	Бусад орлого	биет	25.9	35.4	89.5	54.1	252.8
2	Нийт орлого	сая төг	1,077.3	1,605.8	1,442.1	(163.7)	89.8
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая төг	910.0	1,390.9	1,196.7	(194.2)	86.0
3	Нийт зардал	сая төг	1,028.1	1,604.7	1,194.4	(410.3)	74.4
	Үүнээс: Удирдлагын зардал	сая төг	83.9	86.1	85.6	(0.5)	99.4
4	Татварын өмнөх ашиг	сая төг	(118.1)	1.1	2.3	1.2	209.1
5	Цэвэр ашиг алдагдал	сая төг	(118.1)	1.0	2.1	1.1	210.0
6	Төсвийн төлбөрт	сая төг	296.8	267.8	355.6	87.8	132.7
7	Нийт ажиллагсадын тоо	хүн	38	43	38	(5)	88.4
8	Нийт цалингийн сан	сая төг	370.4	451.6	411.5	(40.1)	91.1
9	Нэг ажилтны дундаж цалин	сая төг	0.8	0.8	0.9	0.1	112.5
10	Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал	төгрөг	1.05	1.0	1.2	0.2	120.0
11	Хөрөнгө оруулалт	сая төг	44.3	149.8	71.6	(78.2)	47.8
12	Нийт авлага	сая төг	228.9	93.7	281.8	188.1	0.0
13	Нийт өглөг	сая төг	285.2	155.7	694.9	539.2	0.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад түрээсийн орлогоос төсөвт төвлөрүүлэх өглөгтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын менежер С.Андруш, захирал В.Даваасүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 1/026 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчаас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 909.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын зорилго нь мэдээлэл технологийг хөгжүүлэх бодлогыг төрөөс дэмжих, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулан төлөвшүүлэх чанартай хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Тус газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг

- Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацын тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах
- Мэдээллийн технологийн үндэсний компаниудыг төлөвшүүлэх, бойжуулах
- Мэдээллийн технологийн өндөр чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэх
- Төрөөс мэдээлэл технологийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 194 дүгээр тогтоолыг үндэслэн шинэчлэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд дараах арга хэмжээ авсан байна.

- Өмчийн бүртгэл ашиглалт хамгаалалтын сайжруулах зорилгоор үндсэн хөрөнгийн программд өөрчлөлт оруулан өмч хөрөнгийг коджуулан бүртгэж, хагас болон бүтэн жилээр захирлын тушаалаар тооллогын комисс томилогдон заавар журмын дагуу тооллого хийсэн байна.
- Засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгын хүрээнд гадаад дотоодын ижил төстэй байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх зорилгоор Япон улсын AOTS, ITPEC байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулсан мөн Азийн шинжлэх ухааны паркуудын холбооны хуралд оролцож байгууллагын танилцуулга хийсэн.
- Байгууллагын дотоод үйл ажиллагаанд холбоотой дүрэм, журам, гэрээ зэрэг нь шаардлагын дагуу боловсруулагдсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг

гаргахгүй байх”-д заасны дагуу удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ТӨБЗГ-ын 2019 оны 260 тоот тогтоолын дагуу үндэслэлтэй тогтоосон байна. Шагнал урамшуулал олгосон, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардал гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21,698.6	1,606.9	(20,091.7)
БХХО	0.00	0.00	0.00
Авлага	228,882.4	281,897.3	53,014.9
Урьдчилгаа	1,052.1	2,092.1	(1,039.9)
Бараа материал	80,168.4	88,382.2	8,213.8
Үндсэн хөрөнгө	2,836,213.5	3,205,844.9	369,631.4
Биет бус хөрөнгө	673,280.0	673,280.0	0.00
Нийт хөрөнгийн дүн	3,841,295.0	4,253,103.3	411,808.3
Өр төлбөрийн дүн	285,180.0	694,920.0	409,740.0
Богино хугацаат өглөг	280,809.1	691,071.4	410,262.3
Урт хугацаат өглөг	4,370.8	3,848.6	(522.2)
Эздийн өмч	3,556,115.0	3,558,183.3	2,068.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,841,295.0	4,253,103.3	411,808.3

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.1 сая төгрөгийн түрээсийн орлогоос орсон мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 1.5 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд нэмүү өртгийн албан татварын авлага 51,8 сая төгрөг, байгууллага болон иргэдээс авах түрээсийн төлбөрийн болон бусад авлага 228.4 сая төгрөг, ажилчдаас авах авлага 1.7 сая төгрөг байна.

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан тоног төхөөрөмжийг хөрөнгөнд бүртгэсэн орлогоос үүссэн татварын байгууллагаас авах нэмүү өртгийн албан татварын авлага 51,8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 223.2 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 58.7 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг шууд аргаар тооцдог байна. Тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй, найдваргүй авлагыг данснаас хассан гүйлгээ гараагүй байна. Найдваргүй авлагыг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Тайлант онд сургалтын гарын авлага хэвлүүлэх ажлын төлбөрт 2.0 сая төгрөг, жолоочийн шатахууны урьдчилгаа 0.1 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 1.0 сая төгрөгийг шатахууны зардлын дансанд шилжүүлэн бүртгэж, зардалд хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88.4 сая төгрөг болж 8,2 сая төгрөгөөр өссөн нь сургалтын материалууд авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд ТБӨЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/1875 тоот албан бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 506.3 сая төгрөгөөр, шинээр 57.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, их засварын зардал 13.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 18.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн А-1/1420 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралтыг үндэслэн нийт 18.3 сая төгрөгийн өртөгтэй, 18.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 10 ширхэг хөрөнгийг акталсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд түрээсийн болон инкубаторын барьцаа, урьдчилж орсон орлого, татварын байгууллага болон хувь хүмүүст төлөх өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2010 онд үүссэн 3.8 сая төгрөгийн өр байна. Энэ нь 2010 онд УБ дулааны сүлжээ төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан дулааны үр ашгийн төсөлд олгосон урт хугацаат зээл байна. Зээлийн төлбөр хуваарийн дагуу төлөгдөж байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тухайн тайлангийн хугацааны туршид байгууллагын үндсэн болон бусад үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг гарсан хэмжээгээр нь, аккруэл сууриар тооцон зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад нийт зардал 166.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь инкубаторын үйл ажиллагааны зардал өссөнөөс шалтгаалжээ.

4.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 641 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,605.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,604.7 сая төгрөгөөр, 1.1 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 149.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол хийгдээгүй байна.

Гүйцэтгэлээр 1,196.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,194.6 сая төгрөгийн зардал гарган, 2.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,196.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 194.2 сая төгрөг буюу 14.0 хувиар тасарсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорионы улмаас оны эхний 9 сарын хугацаанд мэдээлэл технологийн төлөвлөсөн сургалтууд зохион байгуулагдаагүй нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,194.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 410.3 сая төгрөг буюу 25.6 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь ашиглалтын зардал, урсгал засварын зардал, сургалт болон инкубаторын зардал, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардал дутуу гарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2 нэр төрлийн 4 ажилд өөрийн эх үүсвэрээс 71.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1.1 сая төгрөгөөр илүү байгаа нь түрээсийн үйлчилгээний орлого нэмэгдсэн нь нөлөөлж байна.

Тайлант онд 57.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, өөрийн барилгын их засварын ажлын зардалд 13.9 сая төгрөгийг тухайн байгууллагын өөрийн хөрөнгөөр гарсан байна.

ТӨБЗГ-ын 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 363 тоот тогтоолын дагуу тайлант онд түрээсийн төлбөрийн 10 хувь болох 32.2 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 838.9 сая төгрөгийн 104 мэдээллийг Шилэн дансны ...нэгдсэн хуудаст ил тод бүрэн байршуулсан байна

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснөөс 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,873.8	1	3,873.8		0.00	100.0
Албан шаардлага	1	0.00	1	0.00		0.00	100.0
Зөвлөмж	1	500.0	1	500.0		0.00	100.0
Нийт дүн	3	4,373.8		4,373.8		0.00	100.0

/мянган төгрөг/

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ өөрийн байрны 4618.4 ам.метр талбайг үйлчилгээний зориулалтаар 49 аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд түрээсээр ашиглуулах гэрээ байгуулж, авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг гүйцэтгэдэг байна. Тус газрын чиг үүрэг, үйл ажиллагаанд түрээсийн энэхүү үйлчилгээ шаардлагатай эсэхийг судалж, тогтоох, тухайлбал энэ байгууллагын үндсэн чиг үүрэг, зорилгод хамаарал багатай энэхүү нүсэр ажилд хүч, нөөцөө зарцуулдаг боловч үр дүн багатай, өр авлага он удаан жилээр удааширч, төлөгдөхгүй байгаа зэрэг асуудал байна. Уг асуудлыг дараагийн аудитаар авч үзнэ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 150.9 сая төгрөгийн алдаа 5 зөрчил илэрснээс, 75.9 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 4.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

Залруулагдаагүй 4.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын 9.1 сая төгрөгөөс 4.4 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 75.9 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээний нөөц дансны үлдэгдлийг 5.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүүгийн тайлангийн өглөг дансны тодруулгад өглөгийн үлдэгдлийг 1.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Орлогын дэлгэрэнгүй тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 69.0 сая төгрөгийг бусад орлогоор тайлагнасан;

8.2 Албан шаардлага

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангаар 4 байгууллагатай холбоотой 4.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо үүссэн харилцагч тус бүрээр авлагын тооцоо нийлж, баталгаажуулан, баримтжуулж байх албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Түрээсийн орлогын төсөвт төвлөрүүлэх өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2014-2015 онд үүссэн түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг Төрийн өмчийн хороонд /хуучин нэрээр/ өгөх өглөгөөр бүртгэсэн боловч тулган баталгаажуулах албан бичгээр баталгаажуулахад тухайн байгууллагаас авах авлага бүртгэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогын өглөгийг тооцоо нийлэн, төлөх эсэх асуудлыг тодруулан уг асуудлыг дээд шатны төсөв захирагчид хандан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДҮН																								
НИЙТ ДҮН													5	80,650.8	3	75,906.1			1	4,744.7			1	0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 364/АУ/СООС4
АХГ- 2022/33/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1 заалтын дагуу хийсэн Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 3 байгууллагатай холбоотой 4,744,700.00 төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагч тус бүрээр авлагын тооцоо хийж, баримтжуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын захирал Э.Цогтгэрэл, нягтлан бодогч Д.Цэрэндолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ЦЭРЭНЧИМЭД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-244230

Хувийн хэргийн үйлчилгээний газар
Хувийн хэргийн үйлчилгээний газар
C:\Users\Yawsan\Desktop\Bichig_Kherem\Yawsan_Bichig\2022\0315_Auditin 2 Gazar-33.Docx

0010801040

